



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/565

Номгон

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж,
тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчийн байгууллага болон түүнтэй адилтгах босоо чиг үүрэг бүхий байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлагаас 4 агентлаг буюу 17.4% нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 16 агентлаг буюу 69.6% нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 3 агентлаг буюу 13% нь “Үр дүнгүй”, төрийн болон орон нутгийн өмчийн 10 байгууллагаас 1 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн”, 2 байгууллага буюу 20 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 7 байгууллага буюу 70 хувь “Үр дүнгүй”, нийт 20 сумын Засаг даргын Тамгын газрын 45% буюу 9 сум “Үр дүнгүй”, 55% буюу 11 сумын Засаг даргын Тамгын газар “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үр дүн, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутгийн Захиргааны байгууллагуудын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Үр дүнгүй” үнэлэгдсэн Галуут, Бөмбөгөр, Баян -Өндөр, Эрдэнэцогт, Баянлиг, Заг, Жаргалант, Баян-Овоо, Хүрээмарал сумдын Засаг дарга нар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци, Авто тээврийн төв, Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, “Цэвэр хот”

642311481

2.

ОНӨААТҮГ-ын дарга нарт хатуу хариуцлага тооцохыг анхааруулж, доорх арга хэмжээ авч, ажиллахыг үүрэг болгосугай.

1.1. Үйл ажиллагаа нь жигдэрсэн бусад байгууллагуудын тэргүүн туршлагаас судалж, ажлын уялдаа холбоог сайжруулж, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан байгууллагын үйл ажиллагааг тодорхой үр дүнд хүргэх;

1.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжид дүгнэлт хийж, өөрийн байгууллагадаа сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

1.3. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;

2. Хяналт шинжилгээ, үнэлгээний 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны дүнгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн Баянхонгор, Шинэжинст, Баянбулаг, Баацагаан, Жинст, Бууцагаан, Гурванбулаг, Баянговь сумын Засаг дарга, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Цагдаагийн газар, Биеийн тамир, спортын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт байгууллагын үйл ажиллагааг “Тодорхой үр дүн”-д хүргэж ажиллахыг даалгасугай.


3. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, сум орон нутагт гарах үр дүн, үр нөлөө, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх талаар цогц арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Отгонбаяр), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Мандал) нарт даалгасугай.

4. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг зохих түвшинд хүргэж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулан биелэлт, үр дүнг тооцох, мэдээлэх ажлыг сайжруулж, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн зөвлөмжийн биелэлтийг бүрэн биелүүлж ажиллахыг нутгийн захиргааны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Хариуцсан салбартаа холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын чиг үүргийн баримт бичгийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон сум, байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, зөвлөн туслах ажлыг чанартай зохион байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга нарт даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН